


БАТЛАВ:  
“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ”  
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Р.БАТСҮХ

БАТЛАВ.  
“ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН  
ШТАБ”-ЫН ДАРГА, ХОШУУЧ  
ГЕНЕРАЛ



Д.ГАНЗОРИГ

**ТӨМӨР ЗАМЫН СУУРЬ БҮТЦИЙН БУТАЛМАЛ ЧИГЖЭЭС ЧУЛУУ  
(БАЛЛАСТ) БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ**

2020 оны 02 дугаар  
сарын 21-ний өдөр

Дугаар: ХХаГ-20/28-27/07

Улаанбаатар хот

Монгол Улсын Ашигт малтмалын тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйл болон Монгол Улсын зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 315 дугаар тушаалаар байгуулагдсан дэд ажлын хэсгийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 89 дүгээр зөвлөмж, холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн бусад актыг үндэслэн энэхүү гэрээ /цаашид “Гэрээ” гэх/-г:

нэг талаас “МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Р.БАТСҮХ (цаашид “Захиалагч” гэх);

нөгөө талаас “ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 345 ДУГААР НЭГТГЭЛ”, түүнийг төлөөлж, Захирагч бригадын генерал Л.Гансэлэм (цаашид “Нийлүүлэгч” гэх);

нар /цаашид “Талууд” гэх/ дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 Энэхүү гэрээний зорилго нь Нийлүүлэгч нь стандарт, техникийн зохицуулалт, техникийн тодорхойлолтын дагуу үйлдвэрлэгдэж, чанарын шаардлага хангасан биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй Төмөр замын суурь бүтцийн буталмал чигжээс чулуу (балласт) бэлтгэн нийлүүлэх (цаашид “Бүтээгдэхүүн эсхүл ажил, үйлчилгээ” гэх) түүнтэй холбоотой баримт бичгийн хамт Захиалагчийн өмчлөлд шилжүүлэх, Захиалагч нь Нийлүүлэгчид гэрээнд заасан нөхцөлөөр төлбөр тооцоог гүйцэтгэх, Гэрээний талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлагатай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2 Нийлүүлэгч нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулсан, Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд байна. Гэрээг байгуулах, хэрэгжүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл, эрхийг эрх бүхий байгууллагаас авсан, энэ нь гэрээний үүргийг зохих ёсоор бүрэн гүйцэтгэж дуусах хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр, гэрээнд заагдсан ажлыг гүйцэтгэх боловсон хүчний болон санхүүгийн бүрэн чадамжтай этгээд байна.

1.3 Энэхүү гэрээгээр зохицуулаагүй харилцаа, тусгагдаагүй бусад асуудлыг Монгол Улсын бусад хууль тогтоомж, эрх зүйн бусад актад зааснаар шийдвэрлэнэ.

1.4 Дараах бичиг баримтыг гэрээнд хавсаргах бөгөөд эдгээр нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно. Үүнд:

1.4.1 Балластыг нийлүүлэх газрын координат

/Хавсралт 1/

- 1.4.2 техникийн шаардлага, тодорхойлолт; /Захиалагч/ /Хавсралт 2/
- 1.4.3 бүтээгдэхүүний нийлүүлэх тоо хэмжээ, хуваарь; /Хавсралт 3/
- 1.4.4 тухайн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл; /Хавсралт 4/
- 1.4.5 тоног төхөөрөмж, үйлдвэр, техник хэрэгслийн хангамж; /Хавсралт 5/
- 1.4.6 орон нутгийн захиргааны байгууллагын зөвшөөрлүүд /Хавсралт 6/
- 1.4.7 Балластыг эрх бүхий байгууллагаар шинжлүүлсэн шинжилгээний дүн /Хавсралт 7/
- 1.4.8 Балластын материалыг нийлүүлэх эрх бүхий байгууллагын тусгай зөвшөөрөл /Хавсралт 8/

1.5 Захиалагчийн Санхүүгийн хэлтэс, Мэргэжлийн төсөвчин нь гэрээний хавсралтад заасан бүтээгдэхүүн нийлүүлэх үнэ, төсөв, хуваарь, Инженер технологийн хэлтэс нь бүтээгдэхүүний техникийн тодорхойлолт болон гарал үүсэл, чанар, стандартын шаардлага хангасныг гэрчлэх дагалдах баримт, бусад баримт бичгийг тус тус хянан үзсэн байна.

1.6 Энэхүү гэрээнд Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд заасан Уурхайн талбайн булангийн цэгийг төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас баталсан Газрын зураг дээр тэмдэглэж, солбицлуудыг градус, минут, секундээр тодорхойлж хавсаргана.

1.7 Гэрээний үүргийн биелэлтэд Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч болон материалын чанарын туршилт хийх этгээдээр дамжуулан хяналт тавина.

1.8 Гэрээг Талууд байгуулж баталгаажуулсан эсэхээс үл хамааран Ашигт малтмалын тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд заасан шаардлагыг хангаагүй, гэрээний хавсралт, бусад баримт бичгийг ирүүлээгүй байдал нь гэрээ хэрэгжүүлэх нөхцөл бүрдээгүй гэж үзнэ.

### **Хоёр. Гэрээний гол нөхцөл**

Гэрээний үнэ, төлбөрийн нөхцөл

2.1 **Гэрээний нийт үнэ- 5,548,500,000** /таван тэрбум таван зуун дөчин найман сая таван зуун мянга/ төгрөг болно.

2.2 Төсөв, бүтээгдэхүүн нийлүүлэх нэг м.куб нь балластын үнэ **40,500** төгрөг байна.

2.1 Гэрээ байгуулагдсанаар гэрээний нийт үнийн дүнгийн 40%-ийн урьдчилгааг нийлүүлэгчид шилжүүлнэ.

2.2 Үлдэгдэл санхүүжилтийг нийлүүлсэн балластын тоо, хэмжээг үндэслэн гүйцэтгэлээр олгоно. Ингэхдээ урьдчилгаа төлбөрөөс гүйцэтгэлийн хувиар хувь тэнцүүлж суутгана.

2.3 Гэрээний үнэд татвар, хураамж, тээвэрлэлтийн болон ажлын хөлс, ажил гүйцэтгэхэд шаардагдах зардал, бусад холбогдох зардлыг багтаасан ба гэрээний хүчинтэй хугацаанд гэрээний үнэ өөрчлөгдөхгүй болно.

2.4 Бүтээгдэхүүн, ажил гүйцэтгэлийн чанар болон зөрчил, гологдол арилгасан байдлыг хянан үзэж, Бүтээгдэхүүн нийлүүлэлтийг гүйцэтгэлээр тооцож Гэрээний үнийг төлнө.

2.5 Бүтээгдэхүүний тоо хэмжээ, нийлүүлэх хуваарь, төлбөрийн нөхцлийг гэрээний хавсралт 3-д заасны дагуу гүйцэтгэнэ.

2.6 Гэрээний хавсралт 2-д заасан ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан, Гэрээний хавсралт 3-т заасан тоо хэмжээ, хуваарийн дагуу бүтээгдэхүүнийг хүлээж авч акт үйлдэж баталгаажуулна.

2.7 Бүтээгдэхүүний үнийг Захиалагчийн акт, баримтыг үндэслэн Нийлүүлэгчийн нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор Нийлүүлэгчийн Төрийн сан банк дахь 100900014438 тоот төгрөгийн дансанд шилжүүлнэ.

2.8 Гэрээнд заасан бүтээгдэхүүн худалдан авах нийт үнийн дүнгийн 5 хувийг гэрээний хэрэгжилт болон чанарын баталгаа хэлбэрээр барьцаа болгон авч үлдэнэ.

2.9 Бүтээгдэхүүнийг акт, баримт үйлдэн хүлээн авах ба энэ нь Захиалагчийн төлбөр тооцоо хийх үндэслэл болно.

2.10 Талууд ажлын гүйцэтгэлийн талаар харилцан тохиролцож чадаагүй, эсхүл аль нэг талын гаргасан тайлбар, үндэслэл, дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй, тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзсан бол хөндлөнгийн шинжээчээр дүгнэлт гаргуулж, ажлын гүйцэтгэлийг баталгаажуулна. Ийнхүү дүгнэлт гаргуулахад гарсан нэмэлт зардлыг буруутай тал бүрэн хариуцна.

2.11 Бүтээгдэхүүн нийлүүлэх, ажил гүйцэтгэх хугацаанд шаардлагатай үндсэн бараа, материал, түлшний үнэ өссөн, Захиалагчаас үл шалтгаалах байдлаар ажлын өртөг нэмэгдэхтэй холбогдсон эрсдэлийг Гүйцэтгэгч бүрэн хариуцна. Гэрээгээр гүйцэтгэх ажлыг Захиалагчийн өгсөн Ажлын даалгавар, техникийн шаардлагын хүрээнд гүйцэтгэхэд тооцоолоогүй гарсан зардлыг Гүйцэтгэгч хариуцах бөгөөд Гэрээнд үнийн тохируулга хийгдэхгүй.

2.12 Карьерийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл, холбогдох төлбөр, нөөц ашигласан болон газрын төлбөрийг Захиалагч бүрэн хариуцна.

2.13 Төсөл хэрэгжиж дууссаны дараа байгаль орчны техникийн нөхөн сэргээлтийн зардлыг жишиг үнийн дагуу Захиалагч тал, нөхөн сэргээлтийн ажлыг зохих стандарт (шимт хөрсний овоолго хийж буцаан ашиглах, ухмалын дүүргэлт хийх, бортны налууг 45 хэмээс ихгүй байх гэх мэт)-ын дагуу хийж гүйцэтгэх техник тоног төхөөрөмж, ажиллах хүчийг Нийлүүлэгч хариуцна.

### **Гурав. Гэрээний хугацаа, бүтээгдэхүүний баталгаат хугацаа, доголдол арилгах, хүлээн авах**

3.1 **Гэрээний хугацаа.** Гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Орон нутгийн захиргааны байгууллагаас хуульд заасан шаардагдах зөвшөөрлийг албан ёсоор авснаар энэ гэрээ хүчин төгөлдөр болж, ажил, үйчилгээний календарчилсан төлөвлөгөөнд заасан хугацаагаар дуусгавар болгоно.

3.2 Гүйцэтгэгчийн үйл ажиллагаа, зохион байгуулалт, ажил гүйцэтгэхэд шаардагдах техник тоног төхөөрөмжийг тээвэрлэхэд гарсан аливаа саатал, эрсдэл, санхүүгийн хүндрэл, энэ гэрээнд заасны дагуу ажлын гүйцэтгэлийн доголдлыг арилгасан зэрэг нь ажил гүйцэтгэх хугацааг хойшлуулах үндэслэл болохгүй.

3.3 Бүтээгдэхүүн, нийлүүлэлт, ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй, эсхүл хугацаа хожимдуулсан нь ажил гүйцэтгэгчид захиалагчийн зүгээс энэ гэрээнд заасан алданги болон торгууль ногдуулах үндэслэл болно.

3.4 Бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд хэрэглэх материал нь стандартын шаардлагыг хангасан, түүний чанарт материалын туршилт хийгдсэн байх ба бүтээгдэхүүнийг гэрээний хавсралт 3-т заасан хугацааны дотор Нийлүүлэгч нь Захиалагчид тохиролцсон тоо хэмжээгээр хүлээлгэн өгнө.

3.5 Нийлүүлэгч бүтээгдэхүүнийг гэрээний хавсралт 3-т заасан хугацаанд Захиалагчид нийлүүлээгүй, хугацаанд нь хүлээлгэн өгөөгүй, чанарын шаардлага хангаагүй доголдолтой нийлүүлсэн зэргээс хамаарч төмөр замын ажил удааширсан бол

хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар алданги эсхүл учирсан хохирлыг Гүйцэтгэгч Захиалагчид төлнө.

3.6 Байгалийн аюулт үзэгдэл болон гэнэтийн гамшгаас зэрэг Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үүдэн гэрээнд заасан хугацаанд бүтээгдэхүүнийг нийлүүлэх боломжгүй болсон тохиолдолд Нийлүүлэгч Захиалагчид урьдчилан бичгээр мэдэгдэж нийлүүлэх хугацааг тохиролцох эсвэл гэрээг цуцлах хүртэл арга хэмжээг авна.

3.7 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээг цуцалсан тохиолдолд Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөр авсан бол Захиалагчийн анхны шаардлагаар саадгүй төлнө. - 8. (-)

3.8 **Баталгаат хугацаа.** Нийлүүлэгч бүтээгдэхүүнийг хүлээлгэн өгснөөс хойш 3 /гурав/ жилийн хугацаа баталгаа гаргана. /Гэрээний хугацаанд баталгаат хугацаа холбогдох хууль, тогтоомжийн дагуу өөрчлөгдвөл хууль, тогтоомжид заасан хугацааг баримтална/ Баталгаат хугацаанд бүтээгдэхүүнд технологийн горимоос үүдсэн доголдол, чулуулгийн шинж чанараас үүдсэн доголдол илэрсэн бол Гүйцэтгэгч тал хариуцаж, гарсан доголдлыг өөрийн зардал, хөрөнгөөр арилгах эсхүл шинэ бүтээгдэхүүнийг солих, учирсан хохирлоо нөхөн төлөх үүрэгтэй.

3.9 **Бүтээгдэхүүний доголдол.** Энэ зүйлийн 3.8-д зааснаас гадна бүтээгдэхүүний тээвэрлэлтийн дараах худалдан авсан бүтээгдэхүүнд доголдол илэрвэл Нийлүүлэгч нь ажлын 5 хоногийн дотор доголдлыг газар дээр нь арилгах буюу ижил төрлийн өөр шинэ бүтээгдэхүүнээр шууд сольж өгнө.

3.10 Доголдлыг арилгаснаас хойш 3 сарын дотор сольсон бүтээгдэхүүнд бусад согог, үл нийцэл, үл тохирол, доголдол дахин гарсан тухай Захиалагчаас бичгээр мэдэгдэл ирвэл уг доголдлыг Нийлүүлэгч үнэ төлбөргүй шуурхай арилгана.

3.11 Хэрэв доголдол арилгах хугацааг хэтрүүлбэл уг бүтээгдэхүүнийг анхны үнийн дүнгийн 0.3 хувиар алданги тооцон Захиалагчид төлнө. Доголдлыг арилгахтай холбоотой гарсан зардлыг Нийлүүлэгч бүрэн хариуцна.

3.12 Түүнчлэн доголдол гарсан мэдэгдэл хүлээн аваад Нийлүүлэгч гэрээний дагуу түүнийг арилгахгүй бол Захиалагч гэрээний 2.6-т барьцаа болгон тавьсан төлбөрөөс тооцон уг доголдлыг арилгана.

3.13 **Өмчлөлд шилжих.** Энэхүү гэрээнд заасны дагуу бараа бүтээгдэхүүнийг актаар хүлээн авч, төлбөрийг бүрэн төлснөөр тухайн бүтээгдэхүүн Захиалагчийн өмчлөлд бүрэн шилжинэ.

3.14 Бүтээгдэхүүнийг өмчлөх, ашиглах явцад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх зэрэг оюуны өмчийн эрхийг зөрчсөн хэмээн гуравдагч этгээд нэхэмжилсэн тохиолдолд гомдлыг Нийлүүлэгч барагдуулж холбогдон гарах зардлыг хариуцна.

3.15 **Бараа бүтээгдэхүүний хадгалалт** Нийлүүлэгч бүтээгдэхүүнийг эцсийн цэг хүртэл тээвэрлэх явцад үрэгдэж, алдагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор баглаа, бэхэлгээгээр хангана.

3.16 Баглаа, бэхэлгээ нь тээвэрлэлтийн үеийн хатуу нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн болон давс, хур тунадас зэргийг хангалттай тэсвэрлэхээр байна.

3.17 Баглаа, бэхэлгээг сонгохдоо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, түүнчлэн тээвэрлэлтийн цэг бүрд ачих, буулгах хангалттай төхөөрөмж байгаа эсэх зэрэг хүчин зүйлийг харгалзсан байна.

3.18 Баглаа бэхэлгээний гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ гэрээнд, нэн ялангуяа гэрээний Хавсралт 1-д заасан шаардлага болон Захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг чанд мөрдөнө.

## Дөрөв. Талуудын эрх, үүрэг

### 4.1 Нийлүүлэгч, түүний эрх, үүрэг

4.1.1 Нийлүүлэгч нь түгээмэл тархацтай ашигт малтмалын өөрийн орд, уурхайтай байх ба тухайн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй, ашигт малтмал ашиглахад тавих ерөнхий шаардлагыг хангасан, тусгай зөвшөөрөл нь хүчинтэй, бүртгэлтэй, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь төлөгдсөн, тусгай зөвшөөрлийн төлбөрийг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасны дагуу жил бүр төлсөн тусгай зөвшөөрөл эзэмшигч байна.

4.1.2 Нийлүүлэгч нь түгээмэл тархацтай ашигт малтмалыг холбогдох хуульд заасан нөхцөл, журмын дагуу ашиглах, олборлох, үйлдвэрлэсэн, стандартын шаардлагад нийцсэн бүтээгдэхүүнийг зах зээлийн үнээр борлуулах эрхтэй.

Тайлбар: “Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах” гэдгийг Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд заасан түгээмэл тархацтай ашигт малтмалын орд ашиглах газрын гадаргуу, хэвлийгээс ашигт малтмал олборлох, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах үйл ажиллагааг ойлгоно.

4.1.3 Бүтээгдэхүүнийг гэрээнд заасан чанар, стандарт, үзүүлэлтийн дагуу тогтоосон хугацаанд, дагалдах баримт бичгийн хамт хүлээлгэн өгнө.

4.1.4 Бүтээгдэхүүнийг Захиалагчид хүлээлгэн өгөх хүртэл зориулалт, хэрэглээний шинж чанарыг алдагдуулахгүйгээр хадгалах, бүрэн бүтэн байдал, эрсдэлийг хариуцна.

4.1.5 Бүтээгдэхүүний талаар үнэн зөв, бүрэн мэдээллийг өгнө.

4.1.6 Захиалагчид нийлүүлсэн бүтээгдэхүүний талаарх мэдээллийг гуравдагч этгээдэд задруулахгүй байна.

4.1.7 Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор бүрэн биелүүлээгүйгээс Захиалагч болон бусад этгээдэд учруулсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

4.1.8 Нийлүүлэгч нь бүтээгдэхүүнийг нийлүүлэхдээ гэрээний хавсралт 3-т заасан бүтээгдэхүүн нийлүүлэлтийн хуваарийг хатуу мөрдөнө.

4.1.9 Ямар ч тохиолдолд гэрээний үүргийг гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй.

4.1.10 Гэрээний үнийг заасан хугацаанд төлөхийг Захиалагчаас шаардах эрхтэй.

4.1.11 Тусгай зөвшөөрөл эзэмшигч орон нутгийн захиргааны байгууллагатай Байгаль орчныг хамгаалах, түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах гэрээ байгуулж, биелэлтийг хангана.

4.1.12 Ашигт малтмалын тухай хуулийн 35.3.1-35.3.7-д заасан баримт бичгийг бүрдүүлсэн байна.

4.1.13 Тусгай зөвшөөрөл эзэмшигч Соёлын өвийг хамгаалах тухай, Газрын хэвлийн тухай хуульд заасан шаардлагыг хангаж ажиллана.

4.1.14 Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон Ашигт малтмалын тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд заасан үүргийг биелүүлнэ.

4.1.15 Нийлүүлэгч нь хуулийн шаардлага, гэрээний үүргээ биелүүлээгүйгээс бусдад учруулсан хохирол, Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьд Ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу учруулсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

4.1.16 Нийлүүлэгч нь өөрийн ажиллагсдын хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн нөхцөл болон орон нутгийн иргэдийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй.

4.1.17 Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний дагуу ажлыг гүйцэтгэхдээ захиалагчийг явцын хяналтыг хэрэгжүүлэх нөхцөлөөр хангах ажлыг зохион байгуулна.

4.1.18 Захиалагчаас шаардаж буй мэргэжлийн ур чадвар, туршлага, ажиллах хүчинтэй, мэргэжлийн инженер, техникийн ажилтнаас бүрдсэн баг болон өөрийн лаборатори, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй байх ба гэрээнд заасан нөхцөлийн дагуу ажил, үйлчилгээг үзүүлэх чадвартай байна.

## **4.2 Захиалагчийн эрх, үүрэг**

4.2.1 Бүтээгдэхүүнийг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэхийг шаардах, гэрээний үүргийн биелэлт, ажилын гүйцэтгэлд Захиалагч болон түүний ажилтан нь хяналт тавьж, дараах эрх эдэлнэ:

- a. ажлын явцыг газар дээр нь үзэж шалгах, дүрс бичлэг болон фото зургаар баримтжуулах, хамтран шалгаж баталгаажуулах.;
- b. хөндлөнгийн шинжээч ажиллуулах, туршилт хийлгэх, дүгнэлт гаргуулах;
- c. шаардлагатай тайлбар, мэдээлэл, баримт бичгийг гүйцэтгэгчээс гаргуулан авах.

4.2.2 Бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээнд доголдол илэрвэл доголдлыг арилгуулах, уг доголдлыг арилгахад зардал гаргасан бол Нийлүүлэгчээр нөхөн төлүүлэх эрхтэй.

4.2.3 Захиалагч нь техникийн тодорхойлолт, стандарт, шаардлага хангаагүй бүтээгдэхүүнийг үнэ төлбөргүй солиулах эсвэл стандарт, техникийн тодорхойлолтод нийцүүлэх бүхий л арга хэмжээг авах эсхүл захиалгаа цуцлах эрхтэй.

4.2.4 Ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор Захиалагч эсхүл түүний төлөөлөгч бүтээгдэхүүнийг шалгах, турших, хөндлөнгийн лаборатораар шинжлүүлэх эрхтэй.

4.2.5 Шалгалт, туршилтаар бүтээгдэхүүн нь стандарт, техникийн тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд Захиалагч нь тэдгээрээс татгалзах эрхтэй.

4.2.6 Балластыг Дорноговь аймгийн Сайншанд сумын нутаг дэвсгэрт төмөр замын трассын дагуу Худалдан авагчийн заасан газарт хүргэж нийлүүлнэ.

4.2.7 Бүтээгдэхүүнийг тээвэрлэхээс өмнө Захиалагч эсхүл түүний төлөөлөгч шалгасан, туршсан байх нь эцсийн цэгт тээвэрлэн хүргэсний дараа түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд татгалзаж болох Захиалагчийн эрхийг хөндөхгүй.

4.2.8 Гэрээний 4.2.7-д заасан Захиалагч нь шалгаж, туршсан аль ч нөхцөл, болзол нь Нийлүүлэгчийг гэрээний баталгаат хугацааны болон бусад үүргээс чөлөөлөхгүй.

4.2.9 Бүтээгдэхүүний үнийг гэрээнд заасан хугацаанд нэхэмжлэлийн үндсэн дээр шилжүүлнэ.

4.2.10 Бүтээгдэхүүнийг акт, баримт үйлдэн хүлээн авах ба энэ нь төлбөр тооцоо хийх үндэслэл болно.

4.2.11 Эрх бүхий байгууллага шаардсанаар гэрээг дангаар өөрчлөх эрхтэй.

4.2.12 Нийлүүлэгч-тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тайлан, мэдээ зэрэг нууцад хамааруулсан бусад мэдээллийг Төрийн болон албаны нууцын тухай, Байгууллагын нууцын тухай хуульд заасан үндэслэл, журмаас гадуур задруулах, мэдээлэхгүй байх.

## **Тав. Хариуцлага**

5.1 Нийлүүлэгч нь бүтээгдэхүүн нийлүүлэлт, ажил гүйцэтгэлийг хугацаанд нь гүйцэтгээгүй бол ийнхүү хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.3 хувьтай тэнцэх хэмжээний алданги төлнө.

5.2 Гэрээг Захиалагчийн санаачлагаар цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч гэрээний нийт үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний торгууль хүлээх бөгөөд Захиалагчид учирсан хохирлыг бүрэн хариуцна.

5.3 Захиалагч нь энэ гэрээнд заасан үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй бол ийнхүү хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.3 хувьтай тэнцэх хэмжээний алданги хүлээнэ.

5.4 Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн, гэрээнд заасны дагуу нэг талын санаачилгаар гэрээг цуцалсан бол буруутай тал нөгөө талд учруулсан аливаа хохирол болон зардлыг нөхөн төлнө.

5.5 Хэрэв аль нэг тал нь үүргээ биелүүлээгүй тохиолдолд нөгөө тал нь шаардах эрхээ хэрэгжүүлээгүй бол энэ нь эрхээсээ татгалзсан гэж тооцохгүй бөгөөд эрхээ хожим хэрэгжүүлэх, шаардлагатай арга хэмжээ авахад саад болохгүй.

5.6 Нийлүүлэгч бүтээгдэхүүн нийлүүлэлт ажлын үр дүнгийн доголдлын талаар санаатай нуун дарагдуулсан нь хожим илэрвэл тэрээр хариуцлагаас бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлөгдөх үндэслэл болохгүй бөгөөд захиалагч болон гуравдагч этгээдэд учирсан шууд болон шууд бус хохиролыг бүрэн хариуцна.

### **Зургаа. Бусад зүйл**

6.1 Бүтээгдэхүүн тээвэрлэлт. Бүтээгдэхүүн /ачаа/ тээвэрлэлтийг Нийлүүлэгч хариуцах ба тээвэрлэлт хийх явцад өөрийн буруугаас /Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн, техникийн бүрэн бус байдал, жолоочийн хариуцлагагүй байдал, бэхэлгээ дутуу, зам, тээврийн осол, аваараас болж унагаж гэмтээсэн, цаашид ашиглах боломжгүй болсон зэрэг/ үүссэн хохирлыг өөрийн зардлаар барагдуулна.

6.2 Захиалагч нь ачааг хаанаас ачих, хаана хүргэх, явах чиглэл, буулгах газрын байрлалын талаар дэлгэрэнгүй мэдээллийг өгөх үүрэгтэй.

6.3 Ачааны талаар /тоо ширхэг, хүндийн жин, тээвэрлэлтийн нөхцөл, тавигдах шаардлага зэрэг/ үнэн зөв мэдээлэл өгөх үүрэгтэй бөгөөд буруу мэдээлэл өгснөөс холбогдон гарах зардлыг аль нэг буруутай тал бүрэн хариуцна.

6.4 Нийлүүлэгч нь ажил эхлэхийн өмнө автомашины техникийн бэлэн байдал, машины хэвийн ажиллагааг шалгаж ажиллах үүрэгтэй бөгөөд Монгол Улсад мөрдөж байгаа тээврийн харилцааг зохицуулсан хууль, замын хөдөлгөөний дүрэм болон түрээслэгч талын ажлын талбайд баримтлах дүрэм журам, аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдлөг болгон ажиллана.

6.5 Нийлүүлэгч нь техникийн бүрэн бүтэн байдлыг маш сайн хангасан, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэлт гүйцэтгэнэ.

6.6 Тээвэрлэж яваа ачааны бүрэн бүтэн байдлыг хариуцаж, тээвэрлэлтийг түргэн шуурхай явуулах, тээвэрлэх замнал, хугацааг урьдчилан тооцсон байна.

6.7 Нийлүүлэгч товлосон хугацаанд ачааг хүргээгүй бол хэтрүүлсэн хоног тутамд тээврийн хөлсний 0.3 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг Захиалагч талд төлнө.

6.8 Нийлүүлэгч нь хууль тогтоомжид заасны дагуу жолоочийн хариуцлагын даатгал, тээврийн хэрэгслийн болон бусад холбогдох даатгалд даатгуулсан байна.

6.9 Ачааны бэхэлгээ, гадна хучлагыг бүрэн хариуцах ба Тээвэрлүүлэгчийн шаардлагын дагуу, эсвэл шаардлагатай тохиолдолд нэмэлт бэхэлгээ хийнэ.

6.10 Ачааг тээвэрлэхдээ бензин, шатахуун, тос, тээврийн хэрэгсэлд шаардлагатай сэлбэг, багаж хэрэгсэл, хоол хүнс болон холбогдох бусад зардлыг өөрөө дангаар хариуцна.

6.11 Нийлүүлэгч нь энэхүү гэрээний 2.1-т зааснаас өөр ямар нэгэн зардал, төлбөрийг Захиалагчаас шаардах эрхгүй.

### **Долоо. Материалын чанарын хяналт, шинжилгээ хийлгэх**

7.1 Захиалагч нь хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар ажил, үйлчилгээний гүйцэтгэл, материалын чанарын хяналт, шалгалт, шинжилгээ хийлгэх хийлгэж, дүгнэлт гаргуулна.

7.2 Хяналт, шинжилгээний зорилго нь шинээр баригдах төмөр замд хэрэглэгдэх бүтээгдэхүүн, ажил гүйцэтгэл, инженер-геологийн нөхцөлийг / хөрс чулуулаг, гадаргын тогтоц, газрын доорх болон хөрсний нөхцөл, бусад геологи, инженер-геологийн үзэгдэл, үйл явцын нөлөөлөл, хөрс чулуулгийн шинж чанар, төлөв байдлыг/ үнэн зөв тодорхойлох, инженер-геологийн үзүүлэлтийг тогтоох, геологи орчин, нөхцөлд үнэлэлт өгөхөд оршино. Үүнд:

1. Захиалагчаас өгсөн ажлын даалгавар, Техникийн тодорхойлолт, тайланг судалж танилцах, геофизик, туршилт, тойм судалгаа хийх;
2. физик-механик шинж чанар, хэмжилт, тоон зураглал болон бусад ажил, судалгааны тайлан, дүгнэлтийн дагуу явагдаж байгаа эсэхэд өдөр тутам хяналт тавих;
3. Байнгын ажиглалт, хэмжилт, мониторинг хийх, тайлан, дүгнэлт гаргах;
4. Барилгын материалын лабораторын туршилт, шинжилгээ хийх, дүгнэлт гаргах;
5. Инженер-геологи, хөрсний өөрчлөлт, хувиралтын үнэлгээ хийх;
6. Бусад ажил, үйлчилгээ.

### **Найм. Туслан гүйцэтгэгч**

8.1 Нийлүүлэгч нь өөрийн хүчээр гүйцэтгэх боломжгүй ажлын тодорхой хэсгийг мэргэжлийн Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж болно. Энэ тохиолдолд нийлүүлэгч нь Захиалагчийн хувьд Ерөнхий Нийлүүлэгч, туслан Гүйцэтгэгчийн хувьд Захиалагч болно.

8.2 Туслан гүйцэтгэгч нь гүйцэтгэх ажлын онцлогоос хамаарч хуульд заасан аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байна.

8.3 Нийлүүлэгч нь Туслан гүйцэтгэгч авах шаардлагатай хэсэг ажлын жагсаалтыг Захиалагчид урьдчилан танилцуулж, хэсэг ажил тус бүрээр туслан гүйцэтгэгчийг сонгох шалгуур үзүүлэлтэд Захиалагчийн саналыг авч болно.

### **Ес. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, аюулгүй ажиллагаа**

9.1 Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг ашигт малтмалын ашиглалт, уул уурхай, зам, барилгын үйлдвэрлэлийн зориулалтаар Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан эрх бүхий хуулийн этгээд ашиглах ба Тэсэлгээний ажил явуулах этгээд нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан тусгай зөвшөөрөлтэй, мэргэжлийн ажиллах хүчин цагдаагийн болон тагнуулын төв байгууллагын санал, дүгнэлттэй байх, тэсэлгээний ажил явуулах зориулалтын тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, харуул хамгаалалт бүхий агуулахтай байх, тогтоосон хяналтын хуудсыг үндэслэн үйл ажиллагаа явуулна.



9.2 Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалах байр, агуулах дахь аюулгүй ажиллагааны журмыг баримталж, зөвшөөрөгдсөн чиглэлийн дагуу ачаа тээвэрлэлтийн стандарт, ачаа тээвэрлэх дүрэм, аюултай ачаа тээвэрлэх журмыг баримтлан тусгай тоногдсон тээврийн хэрэгслээр тээвэрлэлтийн маршрутын дагуу аюулгүй байдлыг хангаж, харуул хамгаалалттай тээвэрлэнэ.

### **Арав. Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах, маргаан шийдвэрлэх, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, нууц хадгалах**

10.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, гэрээг хэрэгжүүлэх үндсэн нөхцөл болсон тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан, холбогдох төлбөрийг төлөөгүй, байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй талаар эрх бүхий байгууллагаас дүгнэлт гаргасан нь Иргэний хуульд заасны дагуу гэрээнээс татгалзах, улмаар гэрээг цуцлах үндэслэл болно.

10.2 Гэрээг аль нэг талын санаачилгаар гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах тохиолдолд Талууд харилцан ажлын 5 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

10.3 **Маргаан шийдвэрлэх.** Гэрээг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн хүрээнд байгуулсан бөгөөд түүнд заасны дагуу ойлгож, тайлбарлаж, хуулийн дагуу шийдвэрлэнэ.

10.4 Гэрээний хүчинтэй хугацаанд болон түүнээс хойш үүсэх маргаантай асуудлыг Талууд харилцан эв зүйгээр харилцан замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

10.5 Тохиролцоонд эс хүрсэн тохиолдолд Монгол Улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

10.6 **Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах.** Захиалагч Нийлүүлэгчид гэрээнд хэдийд ч нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах бол нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналаа нэг тал нөгөө талдаа харилцан тохирсноос бусад тохиолдолд ажлын 5 хоногийн өмнө бичгээр ирүүлнэ.

10.7 Нэмэлт өөрчлөлтийг бичгээр хийх бөгөөд талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тэмдэг дарж, баталгаажуулсанаар хүчин төгөлдөр болно.

10.8 Нэмэлт өөрчлөлт нь энэ гэрээний салшгүй хэсэг болно.

10.9 **Нууц хадгалах.** Захиалагч талаас өгсөн аливаа нэг мэдээллийн нууцыг гэрээний хугацаа дууссан эсэхээс үл хамааран чанд хадгална.

10.10 Нийлүүлэгч нь Захиалагчийн зөвшөөрөлгүйгээр бүхий л бичиг баримт, тоо мэдээлэл, олж авсан болон цуглуулсан мэдээллээ ямар нэг байдлаар гэрээний үүргийг биелүүлэхээс бусад тохиолдолд олшруулах, нийтэд тараах, нийтлэх, задруулах эрхгүй.

10.11 Нууц хадгалах үүргээ биелүүлээгүйгээс Захиалагчид ямар нэг хохирол учирсан тохиолдолд хохирлыг үл маргах журмаар төлж барагдуулна.

### **Арваннэг. Гэнэтийн болон Давагдашгүй хүчин зүйл**

11.1 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал гэдэгт үерт автах, гал түймэрт нэрвэгдэх, дэлбэрэлтэд өртөх, газар хөдлөх, тахал, халдварт өвчин болон бусад байгалийн хүчин зүйлс мөн цэрэг, дайны үйл ажиллагаа, төрийн эрх барих байгууллагын шийдвэр буюу экспорт, импортын хориг, ажил хаялт зэрэг нь энэ гэрээг зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдал бий болохыг ойлгох ба нөгөө талдаа нэн даруй мэдэгдэнэ.

11.2 Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө

талдаа ажлын таван хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл хуанлийн 30-аас дээш хоногийн хугацаагаар үргэлжилвэл талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

11.3 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлыг зохиомлоор буюу болгоомжгүйгээр бий болгосоноос бусад тохиолдолд давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдлаас шалтгаалан учирсан хохирлыг хариуцах үүргээс талууд харилцан чөлөөлөгдөнө.

11.4 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал үүссэнийг эрх бүхий байгууллага нотолсон байвал зохино.

### Арванхоёр. Гэрээ хүчин төгөлдөр болох

12.1 Энэхүү гэрээ нь Монгол хэл дээр 2 эх хувь байх бөгөөд гэрээний 12.3-д заасныг хангасны үндсэн дээр хоёр талын эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж, дугаар авч, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

12.2 Гэрээтэй холбогдон гарах аливаа мэдэгдэл, шаардлага, захидлууд нь бичгийн хэлбэрээр байх бөгөөд зохих хаягаар хүргэсэн үед тухайн баримтыг хүлээн авсанд тооцно.

12.3 Энэхүү гэрээний 1.4-т заасан хавсралт болон бусад бичиг баримтууд дутуу тохиолдолд гэрээний бүрдэл хэсэг хангагдаагүй гэж үзнэ.


### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

#### Захиалагчийг төлөөлж:


ИНЖЕНЕР, ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН  
ДАРГА

 Д.НЯМЛХАГВА

САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

 Д.ДАВААДОРЖ

ИНЖЕНЕР, ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН  
МАТЕРИАЛЫН ИНЖЕНЕР

 Ө.ТОДСАЙХАН


Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13  
хороолол /14230/, Нарны зам-62  
Юнион бюлдинг А блок 7 давхар

#### Нийлүүлэгчийг төлөөлж:


ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 345 ДУГААР АНГИ  
НЭГТГЭЛИЙН ЗАХИРАГЧИ БРИГАДЫН  
ГЕНЕРАЛ

 Л.ГАНСЭЛЭМ


ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 345 ДУГААР  
НЭГТГЭЛИЙН ЗАХИРАГЧИЙН ОРЛОГЧ, АР  
ТАЛЫН ДАРГА ХУРАНДАА

 Х.ЭРДЭНЭЧИМЭГ

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 345 ДУГААР  
НЭГТГЭЛИЙН ХУУДИЙН ОФИЦЕР  
ХУРАНДАА

 Д.АДЪЯАБАЗАР

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 345 ДУГААР  
НЭГТГЭЛИЙН САНХҮҮГИЙН ДАРГА, АХЛАХ  
НЯГТЛАН БОДОГЧ ХӨШУУЧ

 Б.БАТАА

Утас: 7000-6622, 7010-6655  
И-мэйл: info@mtz.mn

Хаяг: Төв аймаг, Алтанбулаг 2-р баг, Улаан-Хад  
Утас: 88150311, 88270345  
Банкны нэр: Төрийн сан  
Дансны дугаар: 100900014438

ТӨМӨР ЗАМЫН СУУРЬ БҮТЦИЙН БУТАЛМАЛ ЧИГЖЭЭС ЧУЛУУ  
(БАЛЛАСТ) БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ /Хавсралт 1/

БАЛЛАСТЫГ НИЙЛҮҮЛЭХ ГАЗРЫН КООРДИНАТ

№	Үйлдвэр	Бэлтгэн нийлүүлэх байршил
1	Бутлуурын үйлдвэр I	Дорноговь аймаг Сайхандулаан сум X:374169 Y:4925266.3
2	Бутлуурын үйлдвэр II	Дорноговь аймаг Мандах сум N44° 02' 46.6" E108°39' 05.5"

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 345 ДУГААР НЭГТГЭЛИЙН  
ЗАХИРАГЧ БРИГАДЫН ГЕНЕРАЛ



Л.ГАНСЭЛЭМ

ТӨМӨР ЗАМЫН СУУРЬ БҮТЦИЙН БУТАЛМАЛ ЧИГЖЭЭС ЧУЛУУ  
(БАЛЛАСТ) БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ /Хавсралт 3/

БАЛЛАСТЫГ НИЙЛҮҮЛЭХ ТОО ХЭМЖЭЭ, ХУВААРЬ

№	Нийлүүлэх хугацаа	Бетон дэр нийлүүлэх /сар/	Бутлуурын үйлдвэр-1 тоо хэмжээ	Бутлуурын үйлдвэр-2 тоо хэмжээ	Нийт /м.куб/
1	2020 оны 03.1-08.01-н хүртэл	4 сар	5,000	5,000	10,000
2		5 сар	15,000	15,000	30,000
3		6 сар	20,000	20,000	40,000
4		7 сар	28,500	28,500	57,000
	Нийт		68,500	68,500	<b>137,000</b>

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 345 ДУГААР НЭГТГЭЛИЙН  
ЗАХИРАГЧ БРИГАДЫН ГЕНЕРАЛ



Л.ГАНСЭЛЭМ

ТӨМӨР ЗАМЫН СУУРЬ БҮТЦИЙН БУТАЛМАЛ ЧИГЖЭЭС ЧУЛУУ  
(БАЛЛАСТ) БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ /Хавсралт 5/

ҮЙЛДВЭРЛЭЛД АШИГЛАГДАХ ТЕХНИК, ХЭРЭГСЛИЙН ТООЦОО




д/д	Техникийн нэршил	Хэмжих нэгж	тоо ширхэг
1	Ланд-76	Нэгж	3
2	Маяти 5тн кран	Нэгж	1
3	Дугуйт экскаватор	Нэгж	1
4	Усны машин 20 тн	Нэгж	1
5	Портер 1,5тн	Нэгж	1
6	Индүү 12тн доргиуртай	Нэгж	1
7	Автокран 25тн	Нэгж	1
8	Шаланз 100тн /Чиргүүлтэй/	Нэгж	1
10	Экскаватор 5000Вт	Нэгж	2
11	Экскаватор 3000Вт	Нэгж	2
12	Дугуйт ачигч /50 ковш/	Нэгж	4
13	Өөрөө буулгагч 20тн	Нэгж	13
14	Портер 1,5тн	Нэгж	3
15	Запровшка 5тн	Нэгж	1
16	МТО-АТ	Нэгж	1
18	Экскаваторын соёо	ш	2
19	Экскаваторын лоом	ш	2
20	Экскаваторын базуур	ш	2







ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 345 ДУГААР НЭГТГЭЛИЙН  
ЗАХИРАГЧ БРИГАДЫН ГЕНЕРАЛ



Л.ГАНСЭЛЭМ

**ТӨМӨР ЗАМЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХЭД ШААРДАГДАХ  
АВТО, ИНЖЕНЕРИЙН ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

д/д	Техникийн марк, төрөл	Зураг	Техникийн хүчин чадал /тавигдах ерөнхий шаардлага/	
1	Маяти 5тн кран		Шатахууны төрөл	Дизель
			100км шатахуун зарцуулалт /литр/	20
			Шатахууны савны багтаамж /литр/	100
			Өндөрт өргөх чадвар /м/	14,9
			Краны хүчин чадал даац	5тн
			Өргөх чадал /м/	2,5
			Краны радиус /м/	12,1
			Дугуй	Даацын дугуй
2	Дугуйт экскаватор		Ажлын жин	19,8 тн
			Шанаганы багтаамж	0,93 м3 GP Bucket
			Хөдөлгүүрийн хүчин чадал	115kw@2200 rpm
			Малтах өндөр	9,90 м
			Асгах өндөр	6,83 м
			Ухах гүн	6,56 м
			Дугуй	Даацын дугуй
			3	Усны машин 20тн
100км шатахуун зарцуулалт /литр/	25			
Шатахууны савны багтаамж /литр/	130			
Хурдны хайрцаг	Механик			
Суудлын тоо	3			
Тэнхлэг	4*2			
Дугуй	Даацын дугуй			
4	Портер 1,5тн	 UNEGUI		
			Хөдөлгүүрийн багтаамж	2655cc
			Шатахууны савны багтаамж /литр/	60
			Хөдөлгүүрийн хамгийн их хүч	80/4000
			Хөдөлгүүрийн хамгийн их эргэлт	16,8/2400
			Суудлын тоо	3
			Дугуй	Даацын дугуй
			5	HOWO Өөрөө буулгагч
Шатахууны төрөл	Дизель			
100км шатахуун зарцуулалт /литр/	25-32			
Шатахууны савны багтаамж /литр/	400			
Тэвшний багтаамж	20м			
Хүчин чадал /даац/	30тн			
Тэвшний хэмжээ	5800*2300*1800			
Тэнхлэг	6*4			
Дугуй	Даацын дугуй			
6	Индүү 12тн доргиуртай		Ажлын жин	18600тн
			Шатахууны төрөл	Дизель
			Хөдөлгүүрийн чадал буюу эргэх хурд	128/2000
			Доргиурын давтамж	30
			Доргиурын шахалт	1,8/1,2
			Доргиурын чадал	336/224

7	Запровшка 5тн		Үйлдвэрлэгч	KIA
			Даац	5тн
			Шатахууны төрөл	Дизель
			Хөдөлгүүр	0-1000cc
			100км шатахуун зарцуулалт /литр/	10
			Хурдны хайрцаг	Механик
			Суудлын тоо	3
Тэнхлэг	4*2			
8	Автокран 25тн		Загвар	QY25V531
			Шатахууны төрөл	Дизель
			Өргөх хүчин чадал	25тн
			Нэмэлт үзүүрт өргөх хүч	3тн
			Гол сумны өргөх өндөр	39,5м
			Нэмэлт сумны өргөх өндөр	47,2м
			Дугуй	Даацын дугуй
9	Шаланз 100тн /чиргүүлтэй/		Шатахууны төрөл	дизель
			100км шатахуун зарцуулалт /литр/	30
			Хурдны хайрцаг	Механик
			Суудлын тоо	3
			Тэнхлэг	6*4
Дугуй	Даацын дугуй			
10	УАЗ-31519 /хантер/ суудал		Жин	2520 кг
			Шатахууны төрөл	Бензин
			100км шатахуун зарцуулалт /литр/	18
			Шатахууны савны багтаамж /литр/	78
			Хурдны хайрцаг	5
			Дээд хурд	120км/ц
			Эргэх радиус	13,6 м
			Суудлын тоо	5
			Тэнхлэг	4*4
12	Экскаватор 3000Вт		Ажлын жин	48,4 тн
			Шананы багтаамж	3,2 m3 Dart Bucket
			Хөдөлгүүрийн хүчин чадал	330ps@1800 rpm
			Малтах өндөр	12,15 м
			Асгах өндөр	7,85 м
13	Дугуйт ачигч /50 ковш/		Ухах гүн	7,85 м
			Ажиллах үеийн жин /тн/	16940 кг
			Шананы багтаамж /м.куб/	3м3
			Даац /тн/	5000 кг
			Гадна хэмжээ	8080*2980*3410
			Хөдөлгүүр	162kw/2000
			Шатахууны савны багтаамж /литр/	280 литр
			Дугуй	Даацын дугуй





МОНГОЛ УЛС  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

# ТУСТАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар: СБУ 1/012-2020

Байгууллагын нэр

"Зэвсэгт хүчний гурван зуун  
дөчин тав дугаар бригад"  
Т.БАГУТҮГ

Улсын бүртгэлийн дугаар

1470002075

Регистрийн дугаар

3870103

Байгууллагын хаяг


Төв, Алтанбулаг, 2-р баг, Аргал,  
ЗХ-ний сургалтын төв

Монгол Улсын "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 15.15.11, "Төмөр замын тээврийн тухай" хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.7 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 135 дугаар тогтоолыг тус тус үндэслэн

**ТӨМӨР ЗАМЫН СУУРЬ БҮТЭЦ ҮГСРАХ: ДООД БҮТЭЦ БАРИХ /ДАЛАН, ХООЛОЙ/**

тусгай зөвшөөрлийг 2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн 3 /гурав/-н жилийн хугацаатай олгов.

САЙД



Б.ЭНХ-АМГАЛАН

МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот



**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ  
ЗАМ БАРИЛГЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ  
ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨВ ЛАБОРАТОРИ**



**ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН**

**ДАЙРГАНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН**

Дугаар: он/№ 1474/02.20 Чулуу

Олгосон: 2019.12.31

Дээж ирүүлсэн газрын нэр:

Зэвсэгт хүчний бүтээн байгуулалт дэмжлэгийн газар  
Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416.165 км төмөр замд

Объектын нэр:

N 44 02 46.6: E108 39 05.5

Дээжний ордны нэр:

Цементбетон, төмөр замын балласт

Материалын зориулалт:

Материалын инженер Отгонтуул

Дээж авсан хүний нэр, албан тушаал:

Шинжилгээнд ирүүлсэн дээжний

Хүлээн авсан огноо


Шинжилсэн огноо

30кг

2019.12.20

2019.12.20-12.30

Шинжилгээний аргын стандарт	Шинжилсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	Техникийн шаардлага	Үр дүн
MNS BS 812 112:2003	Цохилттой бутрагдалт	%	<25	21.01
MNS ASTM C535-2003	Чулууны элэгдэх чанар тодорхойлох	%	<30	23.76
MNS 2998-2009	Бутрамтгай чанар /цилиндр/	%	<15	9.43
MNS 2998-2009	Чулууны марк		600-1200	1000
MNS 2998-2009	Ус шингээлт	%	<2	0.893
MNS 2998-2009	Ширхэгийн дундаж нягт	г/см <sup>3</sup>	>2.4	2.611
MNS AASHTO T-104	Хүйтэнд тэсвэрдэлт	%	<12	6.84

Хянаж баталгаажуулсан: Лабораторийн эрхлэгч,  Т. Батболд

Шинжилгээ гүйцэтгэсэн: Лабораторийн инженер,  Е. Бумбанцагаан



1/7

Шинжилгээний дүн нь захиалагчаас ирүүлсэн зөвхөн энэ дээжинд хамаарах ба шинжилгээний үр дүнг хуулбарлан хэрэглэхийг хориглоно.

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН  
2019 ОНЫ 10 ДУГААР САРЫН 11-НИЙ ӨДРИЙН  
315 ДУГААР ТУШААЛААР БАЙГУУЛАГДСАН  
ДЭД АЖЛЫН ХЭСГИЙН ЗӨВЛӨМЖ

2020 оны 02 дүгээр  
сарын 14-ны өдөр

Дугаар 29





Улаанбаатар  
хот

“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-Д

Дэд ажлын хэсгийн 2020 оны 02 дугаар сарын .....-ны өдрийн хуралдаанаас гарсан шийдвэрийг үндэслэн ЗӨВЛӨМЖЛӨХ НЬ:

1.Зэвсэгт хүчний Бүтээн байгуулалтын дэмжлэгийн газраас ирүүлсэн саналыг үндэслэн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд эхний ээлжинд шаардлагатай 137.000 м³ балластыг үйлдвэрийн өртөг, тээврийн зардлыг тооцон, цаашид 300.000 м³ хүртэл хэмжээгээр балласт үйлдвэрлэн нийлүүлэхийг Зэвсэгт хүчний 7780 дугаар анги, Зэвсэгт хүчний 345 дугаар бригадад зөвлөмжийг хүргүүлж байна.

2.“Монголын төмөр зам” ТӨХК /Р.Батсүх/ нь Зэвсэгт хүчний 7780 дугаар анги, Зэвсэгт хүчний 345 дугаар бригадтай балласт бэлтгэн нийлүүлэх гэрээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллана уу.

АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА		Д.ГАНЗОРИГ
ГИШҮҮД		
/...../		Ц.НЯМ-ОЧИР
/...../		Ц.БАТЗУЛ
/...../		М.ЭНХБОЛД
/...../		Н.БАЯСГАЛАН
/...../		Н.ЦЭРЭНСАМБУУ
/...../		Э.БАТБАЯР
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА		Б.ЭНЭРЭЛ

УБ-2

Монгол Улсын Засгийн газрын  
2004 оны 20 дугаар тогтоолоор батлав

# МОНГОЛ УЛС УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

2016.08.08

№ 000070697

1470002075

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

/ Улсын бүртгэлийн дугаар /

3870103

/ Регистрийн дугаар /

Зэвсэгт хүчний гурван зуун дөчин тав дугаар  
бригад

Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт  
үйлдвэрийн газар

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Тушаал

н/69

2016.06.20

/ шийдвэрийн нэр /

/ дугаар /

/ он, сар, өдөр /

8422

Батлан хамгаалах үйл ажиллагаа

/ код /

/ Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

/ код /

/ Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

1

1 032 000,00

/ хугацаа /

/ гишүүдийн тоо /

/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Төв, Алтанбулаг, 2-р баг, Аргал, ЗХ-ний сургалтын төв, Утас1: 99056271, Утас2: 88150311, Факс:

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

Төв аймгийн Улсын бүртгэл,  
статистикийн газар

/ бүртгэсэн байгууллагын нэр /

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэлийн

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Огноо	Бүртгэгч
1	Лхагвасүрэн овогтой Гансэлэм-г захирагч-р томилсныг бүртгэв.	2016.08.08	Ш.Батсүх
2	42102 Төмөр замын суурь бүтэц угсрах: доод бүтэц барих /далан хоолой/ /2020.01.06-2023.01.06/ үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2020.02.19	Ш.Батсүх



Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.  
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.